



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2024 оны 08 дугаар сарын 19  
№31 (1327)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠯᠠᠭ ᠠᠯᠪᠠᠨ  
ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

510.	Конвенц соёрхон батлах тухай	2815
511.	Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай	2816
512.	Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2876
513.	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт оруулах тухай	2878
514.	Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	2879
515.	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай	2883
516.	Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт оруулах тухай	2884
517.	Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2885
518.	Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2887
519.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай	2888

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

520.	Хуулийн төсөл буцаах тухай	Дугаар 58	2890
------	----------------------------	-----------	------

### МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

521.	Эрүүгийн хэрэгт эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай Европын конвенц	2891
------	---	------





# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 06 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

## КОНВЕНЦ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Европын зөвлөлөөс Страсбург хотноо 1959 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр баталсан Эрүүгийн хэрэгт эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай Европын конвенцыг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Мөнгөний Фолд\_02 НЭМТ

᠒᠐24 оны 06 сарын 05 өдөр /᠒᠐24 оны 06 сарын 05 өдөр

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠢᠨ ᠳᠠᠷᠭ᠎ᠠ

ᠶ᠋ᠢᠨᠭᠡᠷ ᠵᠢᠢᠯᠢ.ᠶ᠋ᠡᠮᠦᠷᠯᠠᠭ ᠵᠡᠪᠯᠡᠯᠡᠭᠡᠰ ᠰᠢᠷᠠᠰᠦᠷᠭ ᠬᠣᠲᠠᠨᠠᠭ 1959 ᠤᠨ 04 дᠦᠭᠡᠷ ᠰᠠᠷᠢᠨ 20-ᠨᠢ ᠶ᠋ᠡᠳᠦᠷ ᠪᠠᠲᠠᠯᠰᠠᠨ ᠡᠷᠦᠭᠦᠭᠢᠶᠢᠨ ᠬᠡᠷᠦᠭᠲᠡ ᠡᠷᠬᠡ ᠵᠢᠶᠢᠨ ᠬᠠᠷᠢᠯᠴᠠᠭ ᠲᠤᠰᠤᠯᠠᠯᠴᠠᠭ ᠠᠵᠦᠭᠦᠯᠡᠭ ᠲᠤᠭᠠᠢ ᠶ᠋ᠡᠷᠦᠭᠦᠨ ᠭᠠᠵᠢᠷᠢᠨ ᠶ᠋ᠥᠷᠭᠡᠨ ᠮᠡᠳᠦᠭᠦᠯᠰᠢᠨᠡᠷ ᠰᠡᠶᠢᠷᠬᠣᠨ ᠪᠠᠲᠠᠯᠰᠤᠭᠠᠢ.

ᠶ᠋ᠢᠨᠭᠡᠷ ᠵᠢᠢᠯᠢ  
ᠬᠡᠷᠦᠭᠲᠡ ᠡᠷᠬᠡ

ᠭᠡ.ᠵᠠᠨᠳᠠᠨᠰᠠᠲᠠᠷ



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 06 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

### МАЛ, АМЬТНЫ ЭМ, ТЭЖЭЭЛИЙН НЭМЭЛТИЙН ТУХАЙ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

##### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлт, оношлуурын зөвшөөрөл, бүртгэл, үйлдвэрлэл, баталгаажуулалт, худалдаа, хангамж, хэрэглээ, хяналттай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

##### 2 дугаар зүйл.Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн хууль тогтоомж

2.1.Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль<sup>1</sup>, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль<sup>2</sup>, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль<sup>3</sup>, Хэмжил зүйн тухай хууль<sup>4</sup>, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль<sup>5</sup>, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль<sup>6</sup>, Зөвшөөрлийн тухай хууль<sup>7</sup>, болон энэ хууль, эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

##### 3 дугаар зүйл.Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн талаар баримтлах зарчим

<sup>1</sup> Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 01 дугаарт нийтлэгдсэн.  
<sup>2</sup> Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2018 оны 02 дугаарт нийтлэгдсэн.

<sup>3</sup> Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 46 дугаарт нийтлэгдсэн.

<sup>4</sup> Хэмжил зүйн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2019 оны 24 дугаарт нийтлэгдсэн.

<sup>5</sup> Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2018 оны 10 дугаарт нийтлэгдсэн.

<sup>6</sup> Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2024 оны 33 дугаарт нийтлэгдсэн.

<sup>7</sup> Зөвшөөрлийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2022 оны 38 дугаарт нийтлэгдсэн.



3.1.Мал, амьтны эм /цаашид “эм” гэх/, тэжээлийн нэмэлтийн талаар дараах зарчмыг баримтална:

3.1.1.эмийн салбарын ил тод, нээлттэй, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх, эмийн зохицуулалтын цогц тогтолцоог бэхжүүлэх;

3.1.2.эм, эмнэлгийн хэрэгслээр хүртээмжтэй, тогтвортой хангах;

3.1.3.эмийн салбарын үйл ажиллагааг судалгаа, нотолгоонд тулгуурлан явуулж, хөгжлийн чиг хандлагыг оновчтой тодорхойлох;

3.1.4.эмийн салбарыг мэргэшсэн, ур чадвартай хүний нөөцөөр тогтвортой хангах;

3.1.5.эм хангамжийн байгууллагад зохистой дадлыг нэвтрүүлэх;

3.1.6.эм, эмнэлгийн хэрэгсэл, тэжээлийн нэмэлтийн үндэсний үйлдвэрлэлийг дэмжих.

#### **4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“эм” гэж мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчин эмгэгийг оношлох, эмчлэх зориулалттай эм судлал, эмнэлзүйн болон бусад сорилт, туршилтаар үйлдэл нь нотлогдсон нийлэг болон амьтан, ургамал, эрдсийн гаралтай тодорхой хэлбэр, тун, хэмжээтэй бүтээгдэхүүнийг;

4.1.2.“биобэлдмэл” гэж Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 4.1.8-д заасныг;

4.1.3.“ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл” гэж бичил биетнийг идэвхгүйжүүлэх, устгах нийтлэг болон сонгомол үйлчилгээтэй дан болон нийлмэл бүтээгдэхүүнийг;

4.1.4.“тэжээлийн нэмэлт” гэж мал, амьтны бие махбодын үйл ажиллагааг дэмжих, зохицуулах үйлчилгээ бүхий дан болон олон найрлагат бэлдмэлийг;

4.1.5.“оношлуур” гэж мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлох, мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд,



бүтээгдэхүүн болон орчны сорьцын шинжилгээнд хэрэглэдэг тодорхой тун, хэмжээ, найрлага, өвөрмөц чанар, идэвх бүхий бүтээгдэхүүнийг;

4.1.6.“эмийн түүхий эд” гэж Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 4.1.36-д заасныг;

4.1.7.“эмийн гол үйлчлэгч бодис” гэж тухайн эмийн үйлдлийг нөхцөлдүүлэгч дан ба нийлмэл бүрэлдэхүүнтэй биологийн идэвхт нэгдлийг;

4.1.8.“эмийн туслах бодис” гэж эмийн гол үйлдлийг дэмжих, сөрөг нөлөөг бууруулах, амт, үнэрийг дарах ба нэмэгдүүлэх, эмийг хэлбэржүүлэх, найрлагыг тогтворжуулах, үйлдлийн ба хадгалах хугацааг уртасгах зэрэгт шаардлагатай бодисыг;

4.1.9.“эм барих” гэж Эрүүл мэндийн тухай хуулийн<sup>8</sup> 3.1.12-т заасныг;

4.1.10.“цуврал” гэж үйлдвэрлэлийн технологийн нэг удаагийн шат дамжлагаар үйлдвэрлэгдсэн багцын тоо хэмжээг;

4.1.11.“мал, амьтны эмийн бүртгэл” гэж эм зүй, эм судлалын ба бусад судалгааны үндсэн дээр урьдчилан сэргийлэлт, оношилгоо, эмчилгээнд хэрэглэж болох нь нотлогдсон эмийн чанар, аюулгүй байдал, үр нөлөөг хянах, Монгол Улсын хэмжээнд хэрэглэх зөвшөөрөл олгох үйл ажиллагааг.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ ЭМ, БИОБЭЛДМЭЛ, АРИУТГАЛ, ХАЛДВАРГҮЙТГЭЛИЙН БЭЛДМЭЛ, ЭМИЙН ТҮҮХИЙ ЭД, ТЭЖЭЭЛИЙН НЭМЭЛТИЙН БҮРТГЭЛ, БАТАЛГААЖУУЛАЛТ**

### **5 дугаар зүйл.Мал, амьтны эмийн зөвлөл болон фармакопейн хороо**

5.1.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэд төрөөс эм, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий орон тооны бус Мал, амьтны эмийн зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/ болон фармакопейн хороо ажиллана.

5.2.Зөвлөл болон фармакопейн хорооны өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүрэг бүхий албан тушаалтан Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад ажиллана.

<sup>8</sup> Эрүүл мэндийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2011 оны 21 дугаарт нийтлэгдсэн.



5.3.Зөвлөл нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.3.1.эм, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийг бүртгэх, өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасах;

5.3.2.шинээр зохион бүтээсэн эм, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийн сорилтын ба эмнэлзүйн судалгаа, туршилтын дүнг хэлэлцэн шийдвэрлэх;

5.3.3.урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх зориулалттай эм, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг сонгох асуудлаар санал, зөвлөмж боловсруулах;

5.3.4.Монгол Улсад анх удаа импортлон бүртгүүлж байгаа эм, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэлд эмнэлзүйн туршилт хийх шаардлагатай эсэхийг хэлэлцэх;

5.3.5.эм, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийн талаар төрөөс баримтлах бодлогын асуудлаар санал, зөвлөмж боловсруулж, холбогдох төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

5.3.6.тусгай зөвшөөрөл бүхий хангамжийн байгууллагын жилийн тайланг хэлэлцэх, дүгнэлт, зөвлөмж гаргах;

5.3.7.эмийн сэрэмжлүүлэг, аюулгүй байдал, болзошгүй эрсдэлийн асуудлаар мэргэжлийн зөвлөмж гаргах;

5.3.8.фармакопейн хорооны жилийн тайлантай танилцах.

5.4.Зөвлөлийн ажиллах журам, бүрэлдэхүүнийг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

5.5.Фармакопейн хороо нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.5.1.мал эмнэлгийн үндэсний ба үйлдвэрлэгчийн фармакопейн өгүүллийг хэлэлцэн батлах;

5.5.2.фармакопейн өгүүлэлд дугаар олгох;

5.5.3.фармакопейн өгүүллийн нэгдсэн бүртгэл хөтлөх;

5.5.4.фармакопейд нэмэлт, өөрчлөлт оруулах, эмхэтгэн

хэвлэх;



5.5.5.фармакопейн өгүүллийг хүчингүй болгох;  
5.5.6.фармакопейн өгүүллийг боловсруулахад мэргэжлийн зөвлөгөө өгч, хянан магадлах.

5.6.Зөвлөл болон фармакопейн хорооны үйл ажиллагаатай холбогдох зардлыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага жил бүрийн төсвийн төсөлд тусгана.

5.7.Фармакопейн хорооны ажиллах журам, бүрэлдэхүүнийг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

Тайлбар:“фармакопейн өгүүлэл” гэж эмэнд тавих шаардлага, чанарын үзүүлэлт болон тэдгээрийг шинжлэх аргыг заасан зайлшгүй мөрдөх баримт бичгийг, “фармакопей” гэж фармакопейн өгүүллийн эмхэтгэлийг тус тус ойлгоно.

## **6 дугаар зүйл.Эм, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийг бүртгэх**

6.1.Эм, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийг Мал, амьтны эмийн бүртгэлд /цаашид “бүртгэл” гэх/ бүртгэх, өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасах асуудлыг Зөвлөл хэрэгжүүлнэ.

6.2.Доор дурдсан эм, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийг бүртгэлд бүртгэнэ:

6.2.1.энэ зүйлийн 6.3-т зааснаас бусад бүх төрлийн урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх зориулалттай эм, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлт;

6.2.2.тун, хэлбэр, савлагаа, найрлага, хэрэглэх заавар болон үйлдвэрлэлийн технологид өөрчлөлт орсон эм, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлт;

6.2.3.олон улсын зээл, тусламж, хандивын эм, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлт;

6.2.4. үйлдвэрийн аргаар бэлтгэсэн эмчилгээний тун бүхий амин дэм, эмийн эмчилгээг дэмжих, урьдчилан сэргийлэх зориулалттай бэлдмэл.

6.3. Доор дурдсан эм, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлт бүртгэлд хамаарахгүй:

6.3.1. бүртгэлийн дээж;

6.3.2. судалгаа, шинжилгээний ажил, эмнэлзүйн туршилтад хэрэглэх бүтээгдэхүүн;

6.3.3. үзэсгэлэн худалдаанд оролцуулах бүтээгдэхүүн;

6.3.4. эмийн туслах бодис;

6.3.5. цацраг идэвхт бодис, тэдгээрийн бэлдмэл;

6.3.6. химийн урвалж болон бүх төрлийн тэжээлт орчин;

6.3.7. лабораторийн зориулалтаар хэрэглэгдэх будаг;

6.3.8. оношлуур;

6.3.9. тэжээллэг чанартай тэжээлийн нэмэлт.

6.4. Эм, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийг үйлдвэрлэсэн улс, үйлдвэрлэгч, импортлогч, гол үйлчлэгч бодис, хэлбэр, тун, зориулалт, жороор олгох эсэхийг зааж, бүртгэлд 5 жилийн хугацаатайгаар бүртгэнэ.

6.5. Гамшгийн болон онцгой нөхцөл байдал үүссэн үед хэрэглэх эмийг 1 жилийн хугацаатайгаар түргэвчилсэн журмаар бүртгэнэ.

6.6. Шинээр зохион бүтээсэн үндэсний үйлдвэрийн эмийг бүртгэх эсэхийг туршилт, судалгааны тайлан, эрх бүхий байгууллагын дүгнэлтийг үндэслэн хэлэлцэн, шийдвэрлэнэ.

6.7. Үндэсний үйлдвэрийн эм, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийг бүртгүүлэхэд доор дурдсан баримт бичгийг бүрдүүлнэ:

6.7.1. үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл, эмийн түүхий эдийн бүртгэлийн гэрчилгээний хуулбар, үйлдвэрийн танилцуулга, үйлдвэрлэлийн технологийн зураглал;

6.7.2. фармакопейн өгүүлэл;

6.7.3. судалгааны тайланг хэлэлцсэн талаарх мал эмнэлгийн эрдэм шинжилгээний байгууллагын дэргэдэх зөвлөлийн хуралдааны тэмдэглэл;



6.7.4.сорилт, туршилт хийсэн эрх бүхий хөндлөнгийн лабораторийн сорилт, баталгаажуулалтын дүн;

6.7.5.бүтээгдэхүүний тогтвортой байдал, гаж нөлөө, харилцан нөлөөлөл, хорон, эсхүл хоруу чанар, идэвх, аюулгүй байдал, сорилт, туршилт хийсэн судалгааны дэлгэрэнгүй тайлан, дүн;

6.7.6.хэрэглэх зааврын төсөл.

6.8.Импортын эм, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийг бүртгүүлэхэд доор дурдсан баримт бичгийг баталгаажуулсан монгол орчуулгын хамт ирүүлэх бөгөөд ирүүлсэн материалыг буцаан олгохгүй:

6.8.1.үйлдвэрлэгчтэй байгуулсан худалдааны гэрээ, итгэмжлэл;

6.8.2.фармакопейн өгүүлэл;

6.8.3.үйлдвэрлэгчийн танилцуулга, үйлдвэр нь олон улсын стандарт, чанарын шаардлага хангасныг нотлох баримт бичиг;

6.8.4.үйлдвэрлэгч орны болон өөрийн орны эрх бүхий хөндлөнгийн лабораторийн сорилт баталгаажуулалтын дүн;

6.8.5.эм зүй, эмнэлзүйн туршилтын нийтлэгдсэн өгүүлэл, гол үйлчлэгч, туслах бодис, тогтвортой чанарын шинжилгээ, судалгааны дүн, эмийн хорон, эсхүл хоруу чанар, идэвх, найрлага, аюулгүй байдал, харилцан нөлөөллийг судалсан дүн, шошго /монгол, англи хэл дээр баталгаажуулсан байх/;

6.8.6.найрлага, химийн шинж чанар, хэрэглэх, хориглох заалт, гаж нөлөө, эмийн харилцан нөлөөлөл, тун, хадгалах нөхцөл, сэрэмжлүүлэг зэргийг тусгасан баталгаажсан загварын дагуу бичигдсэн хэрэглэх заавар;

Тайлбар: “эмийн гаж нөлөө” гэж мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх зорилгоор зааврын дагуу хэрэглэх явцад илэрч байгаа сөрөг хариу урвалыг ойлгоно.

6.8.7.дээж;

6.8.8.тухайн улсын эрх бүхий байгууллагаас олгосон бүртгэлийн гэрчилгээ;

6.8.9.гарал үүслийн гэрчилгээ;

6.8.10.биобэлдмэл бүртгүүлэхэд дээр дурдагдсан баримт бичгээс гадна олон улсын эрх бүхий лавлагаа лабораторийн шинжилгээний дүгнэлт.

6.9.Эм, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийг үйлдвэрлэсэн улс, үйлдвэрлэгч, хэлбэр, тун тус бүрээр нь бүртгэлд нэг удаа бүртгэнэ.

6.10.Зөвлөл нь энэ хуульд заасан шаардлага хангасан баримт бичгийг хүлээж авснаас хойш 1 сарын дотор, түргэвчилсэн журмаар хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдөрт багтаан шийдвэрлэнэ.

6.11.Дараах тохиолдолд бүртгэлийг шинэчилнэ:

6.11.1.эм, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийн үйлдвэрийн өмчлөлийн хэлбэр, харьяалал, нэр, хаяг, гарал үүсэл өөрчлөгдсөн;

6.11.2.үйлдвэрлэлийн технологи, фармакопейн өгүүлэл, хэрэглэх заавар, тун өөрчлөгдсөн.

6.12.Эм, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийн бүртгэлийн дугаар нь гарал үүсэл, бүртгэгдсэн он, бүртгэлийн хүчинтэй хугацаа, олон улсын эмийн ангиллын томьёолол, эм олгох нөхцөл, хувийн дугаарын талаарх мэдээлэл агуулсан байна.

6.13.Бүртгэлийн хүчинтэй хугацаа, нөхцөл, шаардлагыг зөрчөөгүй тухай хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын болон эрх бүхий хөндлөнгийн лабораторийн дүгнэлтийг үндэслэн бүртгэлийг анх олгосон хугацаанаас доошгүй хугацаагаар сунгана.

6.14.Эм, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийн бүртгэлийн хугацааг сунгасан тохиолдолд бүртгэлийн дугаарыг давтан хэрэглэнэ.

6.15.Дараах тохиолдолд эм, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийг бүртгэлээс хасна:

6.15.1.бүртгэлийн хугацаа дуусахаас 2 сараас доошгүй хугацааны өмнө эм ханган нийлүүлэх байгууллага сунгуулах хүсэлтээ Зөвлөлд ирүүлээгүй;

6.15.2.мал эмнэлгийн эмчилгээ, үйлчилгээнд нийцээгүй буюу гаж нөлөө илэрсэн, хүн, малын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд сөргөөр нөлөөлсөн, өвчний үүсгэгч тухайн эмэнд дасал болсон нь эрх бүхий байгууллагаар тогтоогдсон;

6.15.3.үйлдвэрлэгч эм, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийг хуурамчаар үйлдвэрлэсэн болох нь нотлогдсон.

6.16.Бүртгэлд бүртгүүлэхдээ баримт бичгийг хуурамчаар үйлдсэн болох нь нотлогдсон тохиолдолд эм, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийн бүртгэлийг хүчингүй болгоно.

6.17.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь эм, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийн бүртгэл, мэдээллийн цахим сантай байна.

6.18.Энэ хуулийн 6.17-д заасан цахим санг бүрдүүлэх, эрхлэн хөтлөх журмыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

6.19.Эм, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийн бүртгэлтэй холбоотой зардлыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага жил бүрийн төсвийн төсөлд тусгана.

### **7 дугаар зүйл.Эм, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийн чанарын баталгаажуулалт**

7.1.Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори нь Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 29.2-т зааснаас гадна дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

7.1.1.эм, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийг үйлдвэрлэх, шалгах, хэрэглэхтэй холбоотой зөвлөмж гаргах;

7.1.2.мал эмнэлгийн хэрэгцээнд шинээр нэвтрүүлэх эм, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийг лабораторийн болон хээрийн нөхцөлд сорьж турших;

7.1.3.лабораторийн хяналт шалгалт, туршилт, шинжилгээний ажилд ашигладаг стандарт бодисууд болон мал, амьтны өвчний үүсгэгчийн шалгалтын омгуудыг зохих стандартын дагуу хадгалах, сэргээх, баталгаажуулах, шинэчлэх, шилжүүлэн авах, худалдан авах, нөөц бүрдүүлэх;



7.1.4. сорилт, баталгаажуулалтад хамрагдсан эм, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийн мэдээ, тайланг улирал тутам гаргаж дээд шатны байгууллагад мэдээлэх.

7.2. Эм, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийг шаардлагатай тохиолдолд олон улсын эрх бүхий лавлагаа лабораторид хүргүүлэн баталгаажуулна.

**8 дугаар зүйл. Эм, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийн хаяглалт, түүнд тавих шаардлага**

8.1. Эм, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийн сав, баглаа боодол, шошго, хаяглалт, тэмдэглэгээ дараах мэдээллийг агуулсан байна:

- 8.1.1. худалдааны болон олон улсын нэршил;
- 8.1.2. хэлбэр;
- 8.1.3. найрлага, тун, хэмжээ, тоо ширхэг;
- 8.1.4. үйлдвэрлэгчийн нэр;
- 8.1.5. цувралын дугаар;
- 8.1.6. хэрэглэх арга;
- 8.1.7. үйлдвэрлэсэн он, сар, өдөр, хүчинтэй хугацаа;
- 8.1.8. хадгалах, тээвэрлэх нөхцөл;
- 8.1.9. бүртгэлийн дугаар;
- 8.1.10. фармакопейн өгүүллийн дугаар.

8.2. Энэ хуулийн 8.1.9, 8.1.10 дахь заалт нь зөвхөн үндэсний үйлдвэрлэгчид хамаарна.

8.3. Эм, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн шошго ба хэрэглэх заавар “Зөвхөн мал эмнэлгийн хэрэглээнд зориулав” гэсэн тэмдэглэгээтэй байна.

8.4. Эм, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн хэрэглэх заавар нь монгол хэлээр бичигдсэн байх бөгөөд дараах мэдээллийг агуулна:

- 8.4.1. үйлдвэрлэгчийн нэр, албан ёсны хаяг;
- 8.4.2. худалдааны болон олон улсын нэршил;
- 8.4.3. найрлага, тун, хэмжээ;
- 8.4.4. ангилал, үйлдлийн механизм;
- 8.4.5. хэрэглэх заалт;

- 8.4.6.хэрэглэх арга;
- 8.4.7.гаж нөлөө;
- 8.4.8.хориглох заалт;
- 8.4.9.хүчинтэй хугацаа;
- 8.4.10.хадгалах нөхцөл;
- 8.4.11.биеэс гадагшлах хугацаа;
- 8.4.12.анхааруулга.

8.5.Эм, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн сав, баглаа боодол, шошго, хаяглалт, тэмдэглэгээ, баталгаажсан хэрэглэх зааврыг өөрчлөхийг хориглоно.

**9 дүгээр зүйл.Эм, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлт, оношлуурын судалгаа, шинжилгээ**

9.1.Шинээр бүтээсэн эм, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлт, оношлуур нь эм зүй, эм судлал, хор судлал болон бусад судалгааны дүнгээр баталгаажсан байна.

9.2.Шинэ эм, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлт, оношлуурын талаарх судалгааны тайланг мал эмнэлгийн эрдэм шинжилгээний, эсхүл дээд боловсролын байгууллагын Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, дүгнэлт гаргуулсан байна.

9.3.Хангамжийн байгууллага нь оношлуурыг шинээр хэрэглээнд нэвтрүүлэхээс өмнө Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 29.1-д заасан лабораториор үр дүнгийн харьцуулсан судалгааг хийлгэнэ.

9.4.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь судалгаа, шинжилгээний ажлыг гэрээ, захиалгаар гүйцэтгүүлэх, үр дүнг нэвтрүүлэх ажлыг удирдан зохион байгуулна.

**ГУРАВДУГААР БҮЛЭГ  
ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ, БИОБЭЛДМЭЛ,  
АРИУТГАЛ, ХАЛДВАРГҮЙТГЭЛИЙН БЭЛДМЭЛ, ЭМИЙН  
ТҮҮХИЙ ЭД, ТЭЖЭЭЛИЙН НЭМЭЛТ, ОНОШЛУУРЫН  
ХУДАЛДАА, ХАНГАМЖ, ЗӨВШӨӨРӨЛ**

**10 дугаар зүйл.Эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлт, оношлуурын хангамжийн байгууллага**

10.1.Эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлт, оношлуурын хангамжийн байгууллага /цаашид “хангамжийн байгууллага” гэх/ нь бүртгэлд бүртгэгдсэн, чанарын баталгаатай бүтээгдэхүүнээр мал эмнэлгийн байгууллагыг хүртээмжтэй, тогтвортой хангах зарчмыг үйл ажиллагаандаа баримтална.

10.2.Хангамжийн байгууллагад дараах байгууллага хамаарна:

10.2.1.үйлдвэр;

10.2.2.ханган нийлүүлэх байгууллага;

10.2.3.мал, амьтны эмийн сан /цаашид “эмийн сан” гэх/.

10.3.Энэ хуулийн 10.2.1, 10.2.2-т заасан байгууллага нь эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлт, оношлуурыг бөөний үнээр худалдан борлуулах салбар нэгж байгуулан ажиллаж болно.

10.4.Хангамжийн байгууллага нь үйл ажиллагаандаа зохистой дадлыг нэвтрүүлж, үндэсний стандартыг мөрдөж ажиллана.

10.5.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч хангамжийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавина.

10.6.Хангамжийн байгууллага нь үйлдвэрлэсэн, импортолсон эм, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийн холбогдох баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд зах зээлд нэвтрүүлэхээс нэг сарын өмнө мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад мэдэгдэн, бүртгэлийг шинэчилсэн байна.

10.7.Хангамжийн байгууллагын байршил, барилга байгууламж, мэргэжлийн удирдлага, чанарын менежер өөрчлөгдсөн талаарх мэдээллийг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тухай бүр мэдэгдэнэ.

10.8.Хангамжийн байгууллага нь үйлдвэрлэсэн, импортолсон, нийлүүлсэн эм, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийн жилийн тайланг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тухайн оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор хүргүүлнэ.



10.9.Биобэлдмэлийн улсын нөөц бүрдүүлэх, хадгалах, тээвэрлэх, хэвийн хорогдол тооцох, биоаюултай хог хаягдлыг эгүүлэн татах, устгах журмыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

10.10.Гамшгийн болон онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан байгууллага олон улсын чанарын шаардлага хангасан мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг гадаад улсын үйлдвэрлэгчээс, эсхүл олон улсын байгууллагаас шууд болон дамжуулан худалдан авч болно.

10.11.Энэ хуулийн 10.2-т заасан хангамжийн байгууллагаас бусад хүн, хуулийн этгээд эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлт, оношлуур үйлдвэрлэх, импортлох, худалдах үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

### **11 дүгээр зүйл.Эм, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлт, оношлуурын үйлдвэр**

11.1.Эм, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлт, оношлуурын үйлдвэр /цаашид “үйлдвэр” гэх/ гэж зориулалтын түүхий эд ашиглан стандарт, технологийн дагуу бүтээгдэхүүн үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг ойлгоно.

11.2.Үйлдвэр нь дараах нийтлэг шаардлагыг хангасан байна:

11.2.1.үндэсний болон олон улсын стандартын шаардлага хангасан үйлдвэрлэлийн технологитой байх;

11.2.2.ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан зориулалтын байр, тоног төхөөрөмжөөр хангагдсан байх;

11.2.3.үйлдвэрлэлийн зохистой дадлын шаардлага хангасан байх;

11.2.4.эмийн түүхий эдийг бүртгэлд бүртгүүлсэн байх;

11.2.5.бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг бүрэн хариуцах чанарын хяналтын тогтолцоотой байх;

11.2.6.бүтээгдэхүүний цуврал бүрд хөндлөнгийн чанарын баталгаа гаргуулдаг байх;



11.2.7.бүтээгдэхүүний сав, баглаа боодол, шошго нь стандартын шаардлага хангасан байх.

11.3.Үйлдвэрт дараах үйл ажиллагааг хориглоно:

11.3.1.бүртгэлд бүртгэгдээгүй эмийн түүхий эд хэрэглэх;  
11.3.2.чанарын шаардлага хангаагүй түүхий эдээр үйлдвэрлэл явуулах;

11.3.3.бүтээгдэхүүнийг эмийн бус бүтээгдэхүүнтэй нэг байр, шугам, дамжлагаар үйлдвэрлэх;

11.3.4.хуурамч, стандартын бус бүтээгдэхүүн үйлдвэрлэх;  
11.3.5.мал эмнэлгийн байгууллагыг бүтээгдэхүүн худалдаалсан үр дүнгээр урамшуулах буюу түүнтэй адилтгах үйл ажиллагаанд оролцуулах.

11.4.Энэ хуулийн 10.2.1, 10.2.2-т заасан хуулийн этгээд нь хэрэглэгчийн захиалгын дагуу чанарын баталгаатай биобэлдмэлийг мал эмнэлгийн байгууллагын хяналтын доор зах зээлд нийлүүлнэ.

**12 дугаар зүйл.Эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлт, оношлуурын ханган нийлүүлэх байгууллага**

12.1.Эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлт, оношлуурын ханган нийлүүлэх байгууллага /цаашид “ханган нийлүүлэх байгууллага” гэх/ гэж гэрээний үндсэн дээр эмийн санд бөөнөөр ханган нийлүүлэх хуулийн этгээдийг ойлгоно.

12.2.Ханган нийлүүлэх байгууллага нь үйл ажиллагаандаа холбогдох стандартыг мөрдөнө.

12.3.Ханган нийлүүлэх байгууллага нь дараах нийтлэг шаардлагыг хангасан байна:

12.3.1.мэргэжлийн боловсон хүчний чадавхтай байх;  
12.3.2.импортолсон, ханган нийлүүлсэн бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг бүрэн хариуцах дотоод хяналтын тогтолцоотой байх;

12.3.3.эмнэлгийн хэрэгсэлд шалгалт тохируулга, баталгаажуулалт хийлгэсэн байх;

12.3.4.эмийн санд эм, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг ханган нийлүүлэхдээ цуврал бүрийн чанарын баталгааны нотлох баримтыг дагалдуулах.

12.4.Мал эмнэлгийн байгууллага нь бүртгэлд бүртгэгдсэн, чанарын баталгаатай эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлт, оношлуурыг тусгай зөвшөөрөл бүхий үйлдвэрлэгч, импортлогчоос гэрээний үндсэн дээр худалдан авна.

12.5.Эмнэлгийн хэрэгслийг импортлох, ханган нийлүүлэхэд тухайн бүтээгдэхүүний техникийн болон чанарын баталгаажуулалтын баримт бичгийг хавсаргасан байна.

12.6.Ханган нийлүүлэх байгууллага нийлүүлсэн эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдал, суурилуулалт, сургалт, засвар үйлчилгээ, тохируулгыг баталгаат хугацаанд бүрэн хариуцна.

12.7.Ханган нийлүүлэх байгууллагад дараах зүйлийг хориглоно:

12.7.1.эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлт, оношлуурыг тусгай зөвшөөрөлгүйгээр импортлох;

12.7.2.бүртгэлд бүртгэгдээгүй, чанарын баталгаагүй, шошгогүй, хүчинтэй хугацаа дууссан эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлт, оношлуурыг нийлүүлэх;

12.7.3.мал эмнэлгийн байгууллагыг эм, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлт худалдаалсан үр дүнгээр нь урамшуулах буюу түүнтэй адилтгах үйл ажиллагаанд оролцуулах;

12.7.4.хуурамч, эсхүл бүртгэлд бүртгэгдээгүй эм, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийг импортлох, худалдах;

12.7.5.хадгалалт, түгээлт, ашиглалтын заавар, журам, стандарт зөрчих;

12.7.6.малчин, иргэнд эм, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг худалдах.



12.8. Мал эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт, тохируулга, баталгаажуулалттай холбогдсон энэ хуулиар зохицуулснаас бусад харилцааг Хэмжил зүйн тухай хууль болон бусад хууль тогтоомжоор зохицуулна.

Тайлбар: “эмнэлгийн хэрэгсэл” гэж мал, амьтны өвчин, эмгэгийг оношлох, эмчлэх, сувилах, сэргийлэх, бие махбодын бүтэц, үйл ажиллагааг хянах, орлох, сэргээн засах зорилгоор хэрэглэдэг мал эмнэлгийн болон эмийн үйлдвэрийн тоног төхөөрөмж, түүний дагалт эд зүйл, программ хангамжийг ойлгоно.

### **13 дугаар зүйл. Эмийн сан**

13.1. Эмийн сан гэж эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг жижиглэнгийн үнээр худалдах үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийг ойлгоно.

13.2. Эмийн сан нь үйл ажиллагаандаа холбогдох стандартыг мөрдөнө.

13.3. Эмийн санд эм барих эрх бүхий малын эмч, эсхүл мал эмнэлгийн эм зүйч ажиллана.

13.4. Эмийн сан нь үйлдвэр, ханган нийлүүлэх байгууллагаас эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг гэрээний үндсэн дээр худалдан авна.

13.5. Мал, амьтны эмчилгээ, үйлчилгээнд хэрэглэх хүний эм, эмнэлгийн хэрэгслийн жагсаалтыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

13.6. Мал эмнэлгийн байгууллага, эмийн сан нь энэ хуулийн 13.5-д заасан жагсаалтад орсон эм, эмнэлгийн хэрэгслийг тусгай зөвшөөрөл бүхий хүний эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийн байгууллагаас гэрээний үндсэн дээр худалдан авна.

13.7. Эмийн сангийн үйл ажиллагаанд дараах зүйлийг хориглоно:

13.7.1. энэ хуулийн 13.3-т зааснаас бусад этгээдийг ажиллуулах;

13.7.2. эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн хадгалалт, шошго, тээвэрлэлт, түгээлтийн журам зөрчих;

13.7.3.жороор олгох эмийг жоргүйгээр, эсхүл стандартын бус жороор олгох;

Тайлбар: “мал, амьтны эмийн жор” гэж малын эмчээс эмийн санч, эм зүйч, эм найруулагчид хандан мал, амьтанд зориулан бэлтгэх, олгох, хэрэглэх аргыг заасан баримт бичгийг ойлгоно.

13.7.4.хуурамч, эсхүл бүртгэлд бүртгэгдээгүй эм, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтээр үйлчлэх;

13.7.5.эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг хүнд хэрэглэхээр олгох;

13.7.6.тусламж, хандиваар болон төсвийн хөрөнгөөр нийлүүлсэн эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлт, оношлуурыг үнэлэн худалдах.

#### **14 дүгээр зүйл.Малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгч хүн, хуулийн этгээдэд хориглох зүйл**

14.1.Малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгч хүн, хуулийн этгээдэд дараах зүйлийг хориглоно:

14.1.1.хуурамч, бүртгэлд бүртгэгдээгүй, чанарын баталгаагүй, хүчинтэй хугацаа дууссан эм, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг худалдан авах, хэрэглэх;

14.1.2.зориулалтын бус газарт эм, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлт, оношлуурыг хадгалах;

14.1.3.биобэлдмэл, жороор олгох эмийг малын эмчийн зөвшөөрөлгүй мал, амьтанд хэрэглэх.

#### **15 дугаар зүйл.Эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлт, оношлуурыг улсын хилээр нэвтрүүлэх**

15.1.Эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлт,



оношлуурыг улсын хилээр нэвтрүүлэх хилийн боомтыг Засгийн газар тогтооно.

15.2.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас импортлох, экспортлох энгийн зөвшөөрлийг авна.

15.3.Энгийн зөвшөөрөлд эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлт, оношлуурын нэр, хэлбэр, тун, тоо хэмжээ, үйлдвэрлэгчийн нэр, улсын хилээр нэвтрүүлэх хугацаа, хилийн боомтыг заасан байна.

15.4.Гамшгийн болон онцгой нөхцөл байдал үүссэн үед бүртгэлд бүртгэгдээгүй эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлт, оношлуурыг зайлшгүй шаардлагаар импортлох тохиолдолд Зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр энгийн зөвшөөрөл олгоно.

15.5.Эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлт, оношлуурыг импортлогч нь үйлдвэрлэгч, эсхүл түүний албан ёсны гэрээт борлуулагчтай, экспортлогч нь худалдан авагч байгууллагатай худалдааны гэрээ байгуулсан байна.

15.6.Тусламж, хандивын эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлт, оношлуур нь дараах шаардлагыг хангасан байна:

15.6.1.олон улсын стандартын шаардлага хангасныг нотолсон эрх бүхий байгууллагын тодорхойлолттой байх;

15.6.2.шинээр үйлдвэрлэгдсэн байх, нийлүүлэгдэх үед хоёр жилээс дээш хадгалах хугацаатай барааны хувьд гуравны хоёр нь өнгөрөөгүй, хоёр жил хүртэлх хадгалах хугацаатай барааны хувьд дөрөвний гурав нь өнгөрөөгүй байх;

15.6.3.шошго нь ерөнхий нэршил, хэлбэр, тун, тоо хэмжээ, цувралын дугаар, гарал үүслийн улсын нэр, үйлдвэрлэгчийн нэр, хадгалах нөхцөл болон хугацааны талаарх мэдээллийг агуулсан байх.

15.7.Тусламж, хандиваар эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлт, оношлуур хүлээн авахад тусламж, хандив үзүүлэгч болон хүлээн авагч хоёр тал гэрээ байгуулах бөгөөд гэрээнд дараах зүйлийг тусгана:

15.7.1.тээвэрлэлт, түгээлт, түүнд холбогдон гарах зардлыг хариуцах этгээд;

15.7.2.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль<sup>9</sup> болон Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд<sup>10</sup> заасны дагуу албан татвараас чөлөөлөгдөхөөр зааснаас бусад тусламж, хандивын бараанд ногдох татварыг хариуцах этгээд;

15.7.3.чанарын сорилт, баталгаажуулалттай холбогдон гарах зардлыг хариуцах этгээд, түүний үүрэг;

15.7.4.хүчинтэй хугацаа дууссан, чанарын шаардлага хангахгүй, ашиглах боломжгүй, иж бүрдэл дутуу тохиолдолд хилээр буцаан гаргах болон устгахтай холбогдон гарах зардлыг хариуцах этгээд, хоёр талын харилцан хүлээх үүрэг, хариуцлага.

15.8.Тусламж, хандиваар нийлүүлэх эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлт, оношлуур нь шаардлага хангасан тохиолдолд мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага импортлох энгийн зөвшөөрөл олгоно.

15.9.Тусламж, хандиваар нийлүүлэх эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлт, оношлуурыг улсын хилээр нэвтэрсний дараа тусламж, хандивыг хүлээн авагч нь итгэмжлэгдсэн эрх бүхий лабораторид шинжилгээнд хамруулж чанарыг баталгаажуулна.

15.10.Тусламж, хандиваар нийлүүлэх эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлт, оношлуурыг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөхөд бараа ачигдсан мэдээ, баримтыг тусламж, хандив үзүүлэгч талаас хүлээн авсан даруй хүлээн авагч дараах баримт бичгийг бүрдүүлэн мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ:

15.10.1.татвараас чөлөөлөх тухай албан бичиг;

15.10.2.тусламж, хандив үзүүлэгч болон хүлээн авагч талын хооронд байгуулсан гэрээ;

15.10.3.тээврийн болон үнийн дагалдах баримт, баглаа боодлын жагсаалт, илгээгч байгууллагын тодорхойлолтын хуулбар.

<sup>9</sup> Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2008 оны 23 дугаарт нийтлэгдсэн.

<sup>10</sup> Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2015 оны 29 дугаарт нийтлэгдсэн.



15.11.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ хуулийн 15.10-т заасан баримт бичгийг хүлээн авч татвараас чөлөөлөх тухай албан бичгийг ажлын 5 өдөрт багтаан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

15.12.Эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлт, оношлуурыг импортлох, экспортлоход дараах зүйлийг хориглоно:

15.12.1.энэ хуулийн 15.1-д заасны дагуу тогтоосноос өөр хилийн боомтоор нэвтрүүлэх;

15.12.2.“Монгол Улсад үйлдвэрлэв” гэсэн шошготой эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлт, оношлуурыг импортлох;

15.12.3.тусгай зөвшөөрөлгүй хуулийн этгээд импортлох;  
15.12.4.энгийн зөвшөөрөлд заасан нэр, хэлбэр, тун, тоо хэмжээнээс илүү буюу өөр нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлт, оношлуурыг улсын хилээр нэвтрүүлэх;

15.12.5.мал эмнэлгийн зориулалттай мэдээ алдуулах, өвдөлт намдаах, тайвшруулах эмийг шуудангийн илгээмжээр хүлээн авах;

15.12.6.хадгалалт, тээвэрлэлтийн нөхцөл, горим зөрчсөн нь тогтоогдсон;

15.12.7.тусламж, хандиваар хуурамч, стандартын бус, хадгалалт, тээвэрлэлтийн шаардлага хангаагүй, хүчинтэй хугацаа дууссан эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлт, оношлуурыг нэвтрүүлэх.

15.13.Эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлт, оношлуурыг улсын хилээр нэвтрүүлэхтэй холбоотой энэ хуулиар зохицуулснаас бусад харилцааг Гаалийн тухай хуулиар<sup>11</sup> зохицуулна.

**16 дугаар зүйл.Мал, амьтныг мэдээ алдуулах, өвдөлт намдаах, тайвшруулах эмийн зохицуулалт**

<sup>11</sup> Гаалийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2008 оны 23 дугаарт нийтлэгдсэн.



16.1. Мал эмнэлгийн байгууллага нь мал, амьтныг мэдээ алдуулах, өвдөлт намдаах, тайвшруулах эмийн худалдан авалт, ашиглалт, зарцуулалт, хэрэглээний тайланг хуульд заасан хугацаанд мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад бичгээр, эсхүл цахим хэлбэрээр ирүүлнэ.

16.2. Мал, амьтныг мэдээ алдуулах, өвдөлт намдаах, тайвшруулах эмийн жилийн тайланг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь хуульд заасан хугацаанд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, цагдаагийн төв байгууллагад бичгээр, эсхүл цахим хэлбэрээр хүргүүлнэ.

16.3. Мал, амьтныг мэдээ алдуулах, өвдөлт намдаах, тайвшруулах эмийн худалдан авалт, ашиглалт, зарцуулалт, хэрэглээний явцад мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч хяналт тавина.

16.4. Мал, амьтныг мэдээ алдуулах, өвдөлт намдаах, тайвшруулах эмийг хууль бусаар хэрэглэсэн, зарцуулсан тохиолдолд холбогдох хуулийн дагуу арга хэмжээ авна.

16.5. Мал эмнэлгийн байгууллагад хэрэглэсэн мал, амьтныг мэдээ алдуулах, өвдөлт намдаах, тайвшруулах эмийн орлого, зарлага, устгалын бүртгэл хөтлөх, зарцуулалтыг тайлагнах журмыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

### **17 дугаар зүйл.Эм, эмнэлгийн хэрэгсэл, тэжээлийн нэмэлтийн зөвшөөрөл олгох**

17.1. Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 12.12-т заасан тусгай зөвшөөрөл, 8.2 дугаар зүйлийн 11.4-т заасан энгийн зөвшөөрлийг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тус тус олгоно.

17.2. Үйлдвэрлэх зөвшөөрөл хүсэгч нь Зөвшөөрлийн тухай хуульд зааснаас гадна дараах баримт бичгийг зөвшөөрөл хүссэн өргөдлийн хамт мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ:

17.2.1. үйлдвэрийн барилга, байгууламж, түүний зохион байгуулалт, хүний нөөцтэй холбогдох зохистой дадлын стандарт, техникийн зохицуулалтын шаардлагыг хангасан талаарх мал эмнэлгийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт, нотлох баримт;

17.2.2. үйлдвэрлэлд ашиглах тоног төхөөрөмжийн үндсэн үзүүлэлт, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан тухай баримт бичиг.

17.3.Импортлох зөвшөөрөл хүсэгч нь Зөвшөөрлийн тухай хуульд зааснаас гадна дараах баримт бичгийг зөвшөөрөл хүссэн өргөдлийн хамт мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ:

17.3.1.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

17.3.2.гадаад улсын ханган нийлүүлэгч байгууллагатай байгуулсан худалдааны гэрээ, итгэмжлэл, эсхүл албан ёсны төлөөлөл болохыг нотлох баримт;

17.3.3.үйлдвэрлэгч, эсхүл нийлүүлэгчийн олон улсын чанар, стандартын шаардлага хангасныг нотлох гэрчилгээ.

17.4.Энгийн зөвшөөрөл хүсэгч нь Зөвшөөрлийн тухай хуульд зааснаас гадна дараах баримт бичгийг зөвшөөрөл хүссэн өргөдлийн хамт мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ:

17.4.1.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

17.4.2.үйлдвэрлэгч, эсхүл албан ёсны гэрээт борлуулагчтай байгуулсан худалдааны гэрээ;

17.4.3.бүтээгдэхүүн нь олон улсын чанар, стандартын шаардлага хангасныг нотлох гэрчилгээ;

17.4.4.бүтээгдэхүүний хүчинтэй байх хугацааны дөрөвний гурав нь дуусаагүй болохыг нотлох баримт;

17.4.5.бүтээгдэхүүний нэр, хэлбэр, тун, тоо хэмжээ, сав, баглаа боодол, үйлдвэрлэгчийн нэр, улсын хилээр нэвтрүүлэх хугацаа, хилийн боомтын талаарх мэдээлэл;

17.4.6.ачаа, тээврийн баримтын гаальд бүртгэгдсэн эх хувь, сав, баглаа боодлын дэлгэрэнгүй бүртгэл, нэхэмжлэлийн хуулбар, үйлдвэрлэгчээс олгосон гэрчилгээ.

17.5.Энгийн зөвшөөрөл нь олгосноос хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

17.6.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлд заасан журмыг баримтлан зөвшөөрөл олгох асуудлыг хугацаанд нь шийдвэрлэнэ.



17.7.Тусгай болон энгийн зөвшөөрөлтэй холбогдсон энэ хуулиар зохицуулснаас бусад харилцааг Зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна.

17.8.Эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, оношлуур хангамжийн талаар бүх шатны Засаг дарга нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

17.8.1.мал, амьтны өвчинтэй тэмцэхэд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлэх;

17.8.2.эм, биобэлдмэл, тэжээлийн нэмэлтийн зохистой хэрэглээний талаар соён гэгээрүүлэх, сургалт, сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах.

Тайлбар: “эмийн зохистой хэрэглээ” гэж мал, амьтны эмийг өвчний оношид нийцүүлэн зааврын дагуу зохих тун, зориулалт, тогтоосон давтамжаар хэрэглэхийг ойлгоно.

### **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ МАЛ, АМЬТНЫ ЭМ, ТЭЖЭЭЛИЙН НЭМЭЛТИЙН ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭ**

#### **18 дугаар зүйл.Бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх**

18.1.Тэсвэржсэн бичил биетэнтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхдээ хязгаарлах, орлуулах, хориглох, бүртгэлээс хасах зарчмыг мөрдлөг болгоно.

18.2.Бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх, тэсвэржсэн бичил биетнийг илрүүлэх, хянах үйл ажиллагаа нь эрсдэлийн үнэлгээнд суурилна.

Тайлбар: “бичил биетний тэсвэржилт” гэж ижил зүйлийн мэдрэмтгий бичил биетэнтэй харьцуулахад бичил биетний эсрэг эмийн тунг ихэсгэн хэрэглэсэн тохиолдолд үржсээр байх, эсхүл тогтвортой орших бичил биетний чадварыг ойлгоно.

18.3.Олон улсын жишгийн дагуу шаталсан сайжруулалтын аргад үндэслэсэн бичил биетний тэсвэржилтийн тандалт шинжилгээг итгэмжлэгдсэн лаборатори хэрэгжүүлнэ.

18.4.Бичил биетний тэсвэржилтийг тандах, сэргийлэх, тэмцэх үндэсний төлөвлөгөөг эрүүл мэндийн болон мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

18.5.Бичил биетний тэсвэржилтийг тандах, сэргийлэх, тэмцэх жилийн төлөвлөгөөг үндэсний төлөвлөгөөнд үндэслэн мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга баталж, хэрэгжүүлнэ.

18.6.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага бичил биетний тэсвэржилтийн тандан судалгааны дүн, илэрцийн байдал, хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээллийг холбогдох олон улсын байгууллагад тухай бүр хүргүүлнэ.

### **19 дүгээр зүйл.Мал, амьтны эмийн үлдцээс сэргийлэх**

19.1.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага мал, амьтны биед илрэх эмийн үлдцийн босго үзүүлэлт болон зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн эмийн нэр, тоон үзүүлэлтийн лабораторийн шинжилгээний дүнд үндэслэн олон улсын удирдамжийг баримтлан хариу арга хэмжээг хэрэгжүүлнэ.

19.2.Мал, амьтны гаралтай хүнсний бүтээгдэхүүнд эмийн үлдцийг илрүүлэх, тодорхойлох, баталгаажуулахад олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргыг хэрэглэнэ.

19.3.Эмийн үлдцийг илрүүлэх, хэмжээг тодорхойлох, эрсдэлийг үнэлэх, хянах төлөвлөгөөг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

### **20 дугаар зүйл.Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн зохистой хэрэглээний зохицуулалт**

20.1.Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 28.1-д заасан байгууллага эмийн сэрэмжлүүлгийг өвчний зөв онош, эмийн зөв сонголт, тунгийн зөв сонголт, хэрэглээний зөв арга, цаг хугацааны зөв сонголт гэсэн зарчмыг баримтлан хэрэгжүүлнэ.

Тайлбар: “эмийн сэрэмжлүүлэг” гэж эмийн гаж нөлөөг илрүүлэх, үнэлэх, сэргийлэх үйл ажиллагааг ойлгоно.

20.2.Малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгч нь жоргүй олгох эмийг хэрэглэхдээ малын эмчээс зөвлөгөө, зааварчилгаа авна.

20.3.Мал, амьтныг өвчнөөс сэргийлэх, эмчлэх зориулалтаар хэрэглэх эмийг зааврын дагуу хэрэглэнэ.

20.4.Эмийг жороор олгох журмыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.



20.5.Мал, амьтанд хэрэглэсэн эмийн гаж нөлөө болон бичил биетний тэсвэржилт, мал, амьтны биед үлдэц үүсгэдэг эмийн мэдээллийг мал эмнэлгийн тасаг бүртгэнэ.

20.6.Ханган нийлүүлэх байгууллага нь бичил биетний тэсвэржилт, мал, амьтны биед үлдэц үүсгэдэг эмийн орлого, зарлагын тайланг хагас жил тутамд мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

20.7.Эм, тэжээлийн нэмэлтийг хэрэглэх явцад малын эмч нь эмийн сонголт, аюулгүй хэрэглээ, гаж нөлөө, хэрэглэх зааврыг багтаасан сэрэмжлүүлгийг малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгчид тайлбарлана.

20.8.Эмийн зохистой хэрэглээг хэвшүүлэх сургалт, сурталчилгааг мал эмнэлгийн байгууллага харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулна.

20.9.Малын эмч нь мал, амьтны эмчилгээнд хэрэглэсэн эмийн нэр, огноо, хэрэглэсэн тун, хэмжээний талаарх мэдээллийг тухай бүр тэмдэглэж, баримтжуулна.

20.10.Малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгч нь бүртгэлд бүртгэгдээгүй эм худалдан авах, хэрэглэхийг хориглоно.

20.11.Мал, амьтны эрдэс бодисын дутлыг тодорхойлох тандан судалгааг энэ хуулийн 20.12-т заасан байгууллагын захиалгаар сургалт, эрдэм шинжилгээний байгууллага таван жил тутамд бүсчлэн хийнэ.

20.12.Энэ хуулийн 20.11-д заасан тандан судалгааг үндэслэн мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрдэс бодисын дутлыг нөхөх, хэрэглэх талаар зөвлөмж гаргана.

20.13.Малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгч нь энэ хуулийн 20.12-т заасан зөвлөмжийн дагуу шаардлагатай эрдэс бодисыг агуулсан эм, тэжээлийн нэмэлтийг хэрэглэнэ.

## **ТАВДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ**

**21 дүгээр зүйл.Эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлт, оношлуурт тавих хяналт шалгалт**

21.1.Эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлт, оношлуурын хяналт шалгалтыг аймаг, сум, нийслэл, дүүрэгт мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагч хэрэгжүүлнэ.

21.2.Энэ хуулийн 21.1-д заасан улсын байцаагч нь эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлт, оношлуурын талаар гарсан хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын биелэлтэд хяналт тавина.

21.3.Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.9-д заасан нийтлэг бүрэн эрхээс гадна дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

21.3.1.эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлт, оношлуурыг үйлдвэрлэх, импортлох, худалдах үйл ажиллагааны талаар хүн, хуулийн этгээдээс гаргасан санал, хүсэлтийг хянаж, дүгнэлт гаргах;

21.3.2.эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлт, оношлуурын импортлох тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, малын эмч, эм зүйчийн мэргэжлийн итгэмжлэлийг түдгэлзүүлэх, цуцлах үндэслэл, дүгнэлтээ холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх;

21.3.3.бүртгэлд бүртгэгдээгүй, сорилт, баталгаажуулалт хийгдээгүй, эсхүл олон улсын хэрэглээнээс хасагдсан эм, биобэлдмэл, ариутгал халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийг зах зээлээс эгүүлэн татах саналыг эрх бүхий байгууллагад хүргүүлэх;

21.3.4.зөрчил гаргасан хуулийн этгээдийн үйл ажиллагааг зөрчлийг арилгах хүртэлх хугацаанд бүхэлд нь болон хэсэгчлэн зогсоох, давтан гаргасан бол үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг цуцлах саналыг эрх бүхий байгууллагад хүргүүлэх;

21.3.5.жороор олгох эмийг дур мэдэн хэрэглэсэн бол тухайн хот айл, эрчимжсэн аж ахуйгаас мал, амьтан, тэдгээрийн гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг нийтийн хэрэгцээнд нийлүүлэх эрхийг гурван сараар хязгаарлах;

21.3.6.эм, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтээс дээж авах, чанарын шаардлага хангаагүй тохиолдолд эгүүлэн татах, устгах талаар дүгнэлт гаргах;



21.3.7.хангамжийн байгууллага стандартын шаардлага хангасан эсэхийг хянаж, дүгнэлт гаргах.

21.4.Эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлт, оношлуурын хангамжийн байгууллагын үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас, эрсдэлийн шалгуурыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

**ЗУРГАДУГААР БҮЛЭГ**  
**ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ, БИОБЭЛДМЭЛ, АРИУТГАЛ,**  
**ХАЛДВАРГҮЙТГЭЛИЙН БЭЛДМЭЛ, ЭМИЙН ТҮҮХИЙ ЭД, ТЭЖЭЭЛИЙН**  
**НЭМЭЛТ, ОНОШЛУУРЫН ЗАР СУРТАЛЧИЛГАА**

**22 дугаар зүйл.Эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, ариутгал,**  
**халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд,**  
**тэжээлийн нэмэлт, оношлуурын мэдээлэл**

22.1.Эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлт, оношлуурын талаарх мэдээлэл нь оновчтой, зүй зохистой, үр дүнтэй хэрэглэх, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалахад чиглэсэн байна.

22.2.Зар сурталчилгаанд статистик мэдээ, эм судлалын үзүүлэлт, эмнэлзүйн судалгааны дүн, баримтыг ашиглахдаа эх сурвалжийг заавал тусгасан байна.

22.3.Бүх шатны Засаг дарга малын эмч, эм зүйч, малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгчид эм зүйн мэргэжлийн сургалт, сурталчилгааг бие даан болон холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулна.

22.4.Эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлт, оношлуурыг сурталчлахад Зар сурталчилгааны тухай хуулийн<sup>12</sup> 13.4-т зааснаас гадна дараах зүйлийг хориглоно:

22.4.1.малын эмчийн зөвлөгөө, эмчилгээ, үйлчилгээг үгүйсгэх ойлголт төрүүлэх мэдээлэл өгөх;

22.4.2.эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлт, оношлуурыг ховор, чухал,

<sup>12</sup> Зар сурталчилгааны тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 23 дугаарт нийтлэгдсэн.



цорын ганц, маш өндөр идэвхтэй, үр дүн нь бусад эмээс илүү, аюулгүй, гаж нөлөөгүй, шинэ эм, патентлагдсан гэж хэрэглэгчийг төөрөгдүүлэх;

22.4.3.эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлт, оношлуурын худалдан авалтад урамшуулал олгох буюу үнийн хямдрал үзүүлэх тухай нийтэд сурталчлах.

### **ДОЛДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ**

#### **23 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

23.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэрэг, зөрчлийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд<sup>13</sup> заасан хариуцлага хүлээлгэнэ.

23.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль<sup>14</sup>, эсхүл Зөрчлийн тухай хуульд<sup>15</sup> заасан хариуцлага хүлээлгэнэ.

#### **24 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

24.1.Энэ хуулийг 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

<sup>13</sup> Төрийн албаны тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2018 оны 01 дугаарт нийтлэгдсэн.

<sup>14</sup> Эрүүгийн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2016 оны 07 дугаарт нийтлэгдсэн.

<sup>15</sup> Зөрчлийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2017 оны 24 дугаарт нийтлэгдсэн.













































































## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 06 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

### МАЛ, АМЬТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 11.3 дахь хэсэг нэмсүгэй:

“11.3. Мал, амьтны гоц халдварт, халдварт өвчний жагсаалтад багтсан өвчинтэй тэмцэх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг оролцогч талууд хамтран санхүүжүүлж болно.”

**2 дугаар зүйл.** Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.16 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“4.1.16. “тэжээлийн нэмэлт” гэж Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн 4.1.4-т заасныг;”

**3 дугаар зүйл.** Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай” гэснийг “Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай” гэж өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.** Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 24, 25, 26 дугаар зүйл, 28 дугаар зүйлийн 28.11, 28.12, 28.13 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**5 дугаар зүйл.** Энэ хуулийг Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР





## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 06 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

### МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫН ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Мансууруулах эм, сэтгэгцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль,” гэсний дараа “Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хууль,” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Mongol Folio\_02.html

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠬᠤᠠᠭᠤᠯᠠᠭ ᠤᠯᠤᠰ

ᠮᠤᠨᠰᠤᠸᠠᠰᠤᠷᠤᠯᠠᠬᠤ ᠡᠮ, ᠰᠡᠲᠦᠭᠢᠴᠡᠳ  
ᠨᠥᠯᠥᠭᠡᠲᠦ ᠪᠣᠳᠢᠰᠤᠨ ᠡᠷᠭᠡᠯᠲᠡᠳ  
ᠬᠢᠶ᠋ᠠᠨᠯᠠᠲᠤ ᠲᠠᠪᠢᠬᠤ ᠲᠤᠬᠤᠢ ᠬᠤᠠᠭᠤᠯᠠᠭ  
ᠨᠡᠮᠡᠯᠲᠤ ᠣᠷᠤᠭᠤᠯᠠᠬᠤ ᠲᠤᠬᠤᠢ

ᠠᠨᠨᠢᠭᠦᠷ ᠵᠢᠢᠯᠢ.ᠮᠠᠨᠰᠤᠸᠠᠰᠤᠷᠤᠯᠠᠬᠤ ᠡᠮ, ᠰᠡᠲᠦᠭᠢᠴᠡᠳ  
ᠨᠥᠯᠥᠭᠡᠲᠦ ᠪᠣᠳᠢᠰᠤᠨ ᠡᠷᠭᠡᠯᠲᠡᠳ ᠬᠢᠶ᠋ᠠᠨᠯᠠᠲᠤ ᠲᠠᠪᠢᠬᠤ  
ᠲᠤᠬᠤᠢ ᠬᠤᠠᠭᠤᠯᠠᠭ 2 ᠳᠤᠭᠠᠭ ᠵᠢᠢᠯᠢᠶᠢᠨ 2.1 ᠳᠡᠬᠤ ᠬᠡᠰᠢᠭᠢᠨ  
“ᠡᠮ, ᠡᠮᠨᠡᠯᠢᠭᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭᠦᠰᠢᠯᠢᠶᠢᠨ ᠲᠤᠬᠤᠢ ᠬᠤᠠᠭᠤᠯᠠᠭ,” ᠭᠡᠰᠢᠨᠢ  
ᠳᠠᠷᠠᠭ “ᠮᠠᠯ, ᠠᠮᠢᠶᠢᠨᠢ ᠡᠮ, ᠲᠡᠵᠡᠵᠡᠯᠢᠶᠢᠨ ᠨᠡᠮᠡᠯᠲᠢᠶᠢᠨ  
ᠲᠤᠬᠤᠢ ᠬᠤᠠᠭᠤᠯᠠᠭ,” ᠭᠡᠵᠡ ᠨᠡᠮᠰᠦᠭᠡᠢ.

ᠲᠤᠭᠠᠭ ᠵᠢᠢᠯᠢ.ᠡᠨᠡ ᠬᠤᠠᠭᠤᠯᠠᠭᠢᠭ ᠮᠠᠯ, ᠠᠮᠢᠶᠢᠨᠢ ᠡᠮ,  
ᠲᠡᠵᠡᠵᠡᠯᠢᠶᠢᠨ ᠨᠡᠮᠡᠯᠲᠢᠶᠢᠨ ᠲᠤᠬᠤᠢ ᠬᠤᠠᠭᠤᠯᠠᠭ  
ᠬᠤᠶᠢᠬᠢᠨ ᠬᠤᠠᠭᠤᠯᠠᠭ ᠬᠤᠶᠢᠬᠢᠨ ᠲᠡᠭᠡᠯᠳᠡᠷ ᠪᠣᠯᠰᠣᠨ  
ᠡᠳᠢᠷᠡᠭᠡᠰ ᠡᠬᠢᠯᠡᠨ ᠳᠠᠭᠠᠵᠢ ᠮᠥᠷᠳᠡᠨᠡ.

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ  
ᠶᠢᠬᠤᠨᠠᠭᠤᠯᠠᠭ ᠲᠠᠭᠠ

ᠭ.ᠵᠠᠨᠳᠠᠨᠰᠠᠲᠠᠷ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 06 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Зөрчлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай  
13.10 дугаар зүйл нэмсүгэй:

#### **“13.10 дугаар зүйл.Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хууль зөрчих**

1.Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлт, оношлуурын үйлдвэрлэл эрхлэхэд тавигдах шаардлага, хориглох зүйлийг зөрчсөн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлт, оношлуур импортлоход тавигдах шаардлага, хориглох зүйлийг зөрчсөн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Мал, амьтны эмийн сангийн үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах шаардлага, хориглох зүйлийг зөрчсөн бол хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Эм барих эрх бүхий малын эмч, эсхүл мал эмнэлгийн эм зүйч:

4.1.жороор олгох эмийг жоргүйгээр олгосон;

4.2.эмийг хүчингүй жороор олгосон бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5.Хангамжийн байгууллага, мал эмнэлгийн үйлчилгээний нэгж:

5.1.эмийн бүртгэлд бүртгэгдээгүй, эсхүл чанарын баталгаажуулалтгүй, эсхүл хүчинтэй хугацаа дууссан мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлт, оношлуураар үйлчилсэн;



5.2.эмийн хадгалалт, хамгаалалтын журам зөрчсөн;  
5.3.мал, амьтны эмийн сав, баглаа боодлын хаяглалт, шошго, тэмдэглэгээнд тавигдах шаардлагыг зөрчсөн;

5.4.Монгол Улсад үйлдвэрлэх, импортлох, худалдах мал, амьтны эм, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийг эмийн улсын бүртгэлд бүртгүүлээгүй;

5.5.мал, амьтны эм, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийн чанарын баталгаажуулалтыг хийлгээгүй;

5.6.ашиг орлогоо нэмэгдүүлэх зорилгоор малын эмчийг мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлт, оношлуур худалдах, үр дүнгээр урамшуулах, түүнтэй адилтгах үйл ажиллагаанд оролцуулсан бол хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6.Хуулиар хориглосон хэлбэрээр мал, амьтны эмийн зар сурталчилгаа явуулсан бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

### Индриг Фолг на Хөдл

Хамтын зорилго

2024 оны 1-р сарын 15-ны өдөр

Хамтын зорилго

1. Хамтын зорилго...  
2. Хамтын зорилго...  
3. Хамтын зорилго...

4. Хамтын зорилго...  
5. Хамтын зорилго...  
6. Хамтын зорилго...

7. Хамтын зорилго...  
8. Хамтын зорилго...  
9. Хамтын зорилго...

10. Хамтын зорилго...  
11. Хамтын зорилго...  
12. Хамтын зорилго...

13. Хамтын зорилго...

14. Хамтын зорилго...

15. Хамтын зорилго...

16. Хамтын зорилго...











## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 06 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 4.1.11 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“4.1.11. “мал, амьтны эмийн үлдэц” гэж мал, амьтны гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх малын эм, тэдгээрийн малын биед орж хувирсан нэгдлийн үлдэгдлийг;”

**2 дугаар зүйл.** Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалтын “малын эм, биобэлдмэлийн” гэснийг “мал, амьтны эмийн үлдэц” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР







## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 06 дугаар  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 36 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 36.1.7 дахь заалт нэмсүгэй:

“36.1.7.гамшгийн болон онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд олон улсын чанарын шаардлага хангасан мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг гадаад улсын үйлдвэрлэгчээс, эсхүл олон улсын байгууллагаас шууд болон дамжуулан худалдан авах бол.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Мэдэгдэл

Энэхүү мэдэгдэл нь 2024 оны 10 сарын 15-нд хүчин зүйлээ гүйцэтгэнэ.

Энэхүү мэдэгдэл нь 2024 оны 10 сарын 15-нд хүчин зүйлээ гүйцэтгэнэ.

Энэхүү мэдэгдэл нь 2024 оны 10 сарын 15-нд хүчин зүйлээ гүйцэтгэнэ.

Энэхүү мэдэгдэл нь 2024 оны 10 сарын 15-нд хүчин зүйлээ гүйцэтгэнэ.

Энэхүү мэдэгдэл нь 2024 оны 10 сарын 15-нд хүчин зүйлээ гүйцэтгэнэ.

Мэдэгдэл





## МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

### ЭРҮҮГИЙН ХЭРЭГТ ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦАН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ ЕВРОПЫН КОНВЕНЦ

#### Оршил

Энэхүү конвенцод гарын үсэг зурсан Европын Зөвлөлийн гишүүд болох Засгийн газрууд,

Европын Зөвлөлийн гол зорилго нь өөрийн гишүүдийн хооронд нягт хамтын ажиллагаа, харилцаа тогтоох хэмээн үзэж,

эрүүгийн хэрэгт эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх салбарт нийтлэг журмыг хүлээн зөвшөөрөх нь дээрх зорилгод хүрэхэд хувь нэмэр оруулна гэдэгт итгэж,

ийм эрх зүйн харилцан туслалцаа нь 1957 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн конвенцоор зохицуулсан гэмт этгээдийг шилжүүлэхтэй уялдаж байна хэмээн үзэж,

дараах зүйлийг хэлэлцэн тохиролцов:

#### I бүлэг Ерөнхий заалт

##### 1 дүгээр зүйл

1. Туслалцаа үзүүлэх тухай хүсэлт гаргах үед хүсэлт гаргагч Талын шүүх эрх мэдлийн байгууллагын харьяалалд хянан шалгагдаж буй бүхий л гэмт хэргийг хянан шийдвэрлэхэд Хэлэлцэн тохиролцогч Талууд нэг нэгэндээ энэхүү конвенцын заалтын дагуу хамгийн өргөн хүрээнд эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх үүрэг хүлээнэ.

2. Энэхүү конвенц нь баривчилгаа, тогтоол гүйцэтгэх ажиллагаа болон ердийн эрүүгийн хуулиар гэмт хэрэгт тооцдоггүй боловч цэргийн хуульд заасан гэмт хэрэгт хамаарахгүй.

##### 2 дугаар зүйл

Дараах тохиолдолд туслалцаа үзүүлэхээс татгалзаж болно:

- Хүсэлт хүлээн авагч Тал хүсэлтэд дурдсан гэмт хэргийг улс төрийн гэмт хэрэг, улс төрийн гэмт хэрэгтэй холбоотой гэмт хэрэг, эсхүл улсын төсвийн эсрэг гэмт хэрэг гэж үзвэл;



- b. Хүсэлт хүлээн авагч Тал хүсэлтийг биелүүлэх нь хүсэлт хүлээн авагч Талын улсын тусгаар тогтнол, аюулгүй байдал, нийгмийн дэг журам болон бусад чухал ашиг сонирхолд хохирол учруулахаар байна гэж үзвэл.

## **II бүлэг**

### **Эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай хүсэлт**

#### **3 дугаар зүйл**

1. Хүсэлт хүлээн авагч Тал эрүүгийн хэрэгтэй холбоотой бөгөөд нотлох баримт авах, эсхүл эд мөрийн баримт, материал буюу баримт бичгийг дамжуулах зорилгоор хүсэлт гаргагч Талын шүүх эрх мэдлийн байгууллагаас ирүүлсэн аливаа эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай хүсэлтийг өөрийн хууль тогтоомжид заасан журмын дагуу гүйцэтгэнэ.

2. Хэрэв хүсэлт гаргагч Тал гэрч болон шинжээчийг мэдүүлэг өгөхөд нь тангараг өргүүлэхийг хүсвэл энэхүү хүсэлтээ тусгайлан илэрхийлнэ; мөн хүсэлт хүлээн авагч Тал, өөрийн улсын хууль тогтоомжоор хориглоогүй бол, энэхүү хүсэлтийг гүйцэтгэнэ.

3. Хүсэлт гаргагч Тал материал буюу баримт бичгийн эх хувийг ирүүлэхийг тусгайлан хүссэнээс бусад тохиолдолд хүсэлт хүлээн авагч Тал тэдгээрийн баталгаажуулсан хуулбар, эсхүл фото-хуулбарыг хүргүүлнэ. Хэрэв эх хувийг хүссэн бол хүсэлт хүлээн авагч Тал хүсэлтийг биелүүлэх бүх хүчин чармайлтыг гаргана.

#### **4 дүгээр зүйл**

Хүсэлт гаргагч Талын тусгайлан гаргасан хүсэлтийн дагуу хүсэлт хүлээн авагч Тал түүнд эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай хүсэлтийг гүйцэтгэх газар, он, сар, өдрийг мэдээлнэ. Хүсэлт хүлээн авагч Тал зөвшөөрсөн тохиолдолд эрх бүхий байгууллагын төлөөлөл болон холбогдох этгээдийг байлцуулж болно.

#### **5 дугаар зүйл**

1. Хэлэлцэн тохиролцогч аливаа Тал энэхүү конвенцод гарын үсэг зурах, эсхүл соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулах үедээ Европын Зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэл хүргүүлэх замаар дараах нөхцөлийн аль нэг, эсхүл хэд хэдийг хангасан эсэхээс хамаарч өмч хөрөнгийг нэгжих буюу битүүмжлэхэд эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай хүсэлтийг гүйцэтгэх эрхээ хадгалж болно:



- a. эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай хүсэлт гаргах болсон гэмт хэрэгт хүсэлт гаргагч Талын хууль болон хүсэлт хүлээн авагч Талын хуулийн аль алиных нь дагуу хариуцлага хүлээлгэх боломжтой байх;
- b. эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай хүсэлтэд холбогдох гэмт хэрэг нь хүсэлт хүлээн авагч улсад шилжүүлэх боломжтой гэмт хэрэг байх;
- c. эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай хүсэлтийг гүйцэтгэх нь хүсэлт хүлээн авагч Талын хууль тогтоомжид нийцсэн байх.

2. Хэлэлцэн тохиролцогч аль нэг Тал энэхүү зүйлийн 1 дэх хэсгийн дагуу мэдэгдэл гаргасан бол Хэлэлцэн тохиролцогч аливаа нөгөө Тал харилцан адил байх зарчмыг хэрэглэж болно.

### **6 дугаар зүйл**

1. Шилжүүлэн өгөхийг хүссэн эд хөрөнгө, материал болон баримт бичиг нь явцдаа байгаа эрүүгийн хянан шийдвэрлэх ажиллагаанд шаардлагатай бол хүсэлт хүлээн авагч Тал тэдгээр эд хөрөнгө, материал буюу баримт бичгийг шилжүүлэн өгөхийг хойшлуулж болно.

2. Хүсэлт гаргагч Тал нь эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай хүсэлтийг гүйцэтгэх хүрээнд шилжүүлэн авсан аливаа эд хөрөнгө, материал буюу баримт бичгийн эх хувийг, хүсэлт хүлээн авагч Тал татгалзсанаас бусад тохиолдолд, хамгийн богино хугацаанд буцаан өгнө.

### **III бүлэг**

#### **Мэдэгдэх хуудас болон шүүхийн тогтоолыг гардуулж өгөх Гэрч, шинжээч, яллагдагчийг дуудан ирүүлэх**

### **7 дугаар зүйл**

1. Хүсэлт хүлээн авагч Тал хүсэлт гаргагч Талаас гардуулан өгөх зорилгоор ирүүлсэн мэдэгдэх хуудас болон шүүхийн тогтоолыг гардуулан өгөх ажиллагааг гүйцэтгэнэ.

Гардуулж өгөх ажиллагааг мэдэгдэх хуудас болон шүүхийн тогтоолыг хүлээн авагчид ердийн байдлаар гардуулан өгөх байдлаар гүйцэтгэж болно. Хүсэлт гаргагч Талын тусгайлсан хүсэлтийн дагуу хүсэлт хүлээн авагч Тал нь өөрийн улсын хууль тогтоомжид заасан адил төстэй баримт бичгийн хувьд хэрэглэдэг журам, эсхүл эдгээр хууль тогтоомжид нийцэх тусгай журмын дагуу гардуулан өгөх ажиллагааг гүйцэтгэж болно.

2. Гардуулан өгөх ажиллагааг хүлээн авагчийн гарын үсэг болон огноо бүхий хүлээн авагчийн мэдэгдлээр, эсхүл гардуулан өгөх ажиллагааг гүйцэтгэсэн хэлбэр болон огноо бүхий хүсэлт хүлээн авагч Талын мэдэгдлээр баталгаажуулна. Эдгээр баримт бичгийн аль нэгийг болон бүгдийг нь нэн даруй хүсэлт гаргагч Талд хүргүүлнэ. Хүсэлт гаргагч Талын хүсэлтээр гардуулан өгөх ажиллагаа нь хүсэлт хүлээн авагч Талын хуулийн дагуу явагдсаныг хүсэлт хүлээн авагч Тал тодорхойлно. Хүсэлт гаргагч Тал гардуулан өгөх ажиллагааг гүйцэтгэж чадаагүй бол шалтгааныг нь нэн даруй хүсэлт гаргагч Талд мэдэгдэнэ.

3. Аливаа Хэлэлцэн тохиролцогч Тал энэхүү конвенцод гарын үсэг зурах, эсхүл батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулахаар хүргүүлэх үедээ Европын Зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн даргад хандан мэдэгдэл гаргах замаар зарлан дуудах хуудсыг өөрийн улсын нутаг дэвсгэр дээр байгаа яллагдагчид өөрийн улсын эрх бүхий байгууллагад хүрэлцэн ирэх өдрөөс тодорхой хугацааны өмнө ирүүлж байхыг хүсэж болно. Энэхүү хугацааг дээр дурдсан мэдэгдэлд заах бөгөөд 50 хоногоос хэтэрч болохгүй.

Энэхүү хугацааг хүрэлцэн ирэх өдрийг товлох болон зарлан дуудах хуудсыг дамжуулах хугацааг тодорхойлоход харгалзан үзнэ.

### **8 дугаар зүйл**

Хүсэлтийн дагуу гардуулан өгсөн зарлан дуудах хуудсанд хариу өгөөгүй гэрч, эсхүл шинжээч нь хүсэлт гаргагч Талын нутаг дэвсгэрт дараа нь сайн дураараа ирээд дахин зарлан дуудах хуудсыг зохих ёсоор хүлээн аваагүй бол тэдгээрт уг зарлан дуудах хуудаст хариуцлага хүлээлгэх тухай тэмдэглэсэн байсан ч гэсэн аливаа ял шийтгэл ногдуулахгүй бөгөөд таслан сэргийлэх арга хэмжээ авахгүй.

### **9 дүгээр зүйл**

Хүсэлт гаргагч Талаас гэрч, эсхүл шинжээчид олгох амьжиргааны тэтгэмж болон тээврийн зардлын төлбөрийн хэмжээг тэдгээрийн оршин суугаа газрын жишгээр тооцоолох бөгөөд хамгийн багадаа шүүх ажиллагаа явагдах улсад мөрдөгдөж байгаа үнэ тариф болон журамд заасан хэмжээтэй адил байна.

### **10 дугаар зүйл**

1. Хүсэлт гаргагч Тал гэрч, эсхүл шинжээчийг шүүх эрх мэдлийн байгууллагад өөрийн биеэр хүрэлцэн ирэх онцгой шаардлагатай гэж үзвэл энэ тухайгаа зарлан дуудах хуудас гардуулан өгөх тухай хүсэлтэд тусгасан байх ба хүсэлт хүлээн авагч Тал гэрч буюу шинжээчийг хүрэлцэн ирэхийг урина.

Хүсэлт хүлээн авагч Тал тухайн гэрч буюу шинжээчийн хариуг хүсэлт гаргагч Талд мэдээлнэ.

2. Энэхүү зүйлийн 1 дэх хэсэгт заасан тодорхой тохиолдолд төлбөр, амьжиргааны болон замын зардлын буцаан олгох хэмжээг хүсэлт, эсхүл зарлан дуудах хуудсанд ойролцоогоор тусгасан байна.

3. Тусгайлсан хүсэлтийн дагуу хүсэлт хүлээн авагч Тал гэрч, эсхүл шинжээчид урьдчилгаа олгож болно. Урьдчилгааны хэмжээг зарлан дуудах хуудсанд дурдсан байх бөгөөд хүсэлт гаргагч Тал төлнө.

### **11 дүгээр зүйл**

1. Хүсэлт гаргагч Талын хүсэлтийн дагуу хүсэлт хүлээн авагч Талын тогтоосон хугацаанд, 12 дугаар зүйлийг түүний зохицуулалтыг хэрэглэх хүрээнд баримтлан, буцаан хүргүүлэх нөхцөлтэйгөөр саатуулагдсан этгээдийг гэрчээр асуух, эсхүл нүүрэлдүүлэх зорилгоор шүүх ажиллагаа явагдах нутаг дэвсгэр рүү түр хугацаагаар шилжүүлнэ.

Шилжүүлэхээс дараах тохиолдолд татгалзаж болно:

- a. саатуулагдсан этгээд зөвшөөрөөгүй бол;
- b. саатуулагдсан этгээд хүсэлт хүлээн авагч Талын нутаг дэвсгэрт эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох шаардлагатай бол;
- c. түүнийг шилжүүлэх нь түүний саатуулагдах хугацааг нэмэгдүүлэхээр бол;
- d. хүсэлт гаргагч Талын нутаг дэвсгэр рүү түүнийг шилжүүлэхгүй байх ноцтой үндэслэл байгаа бол.

2. Дээрх хэсэгт заасан тохиолдолд энэхүү конвенцын 2 дугаар зүйлд заасныг харгалзан саатуулагдсан этгээдийг энэхүү конвенцын хэлэлцэн тохиролцогч нэг Тал болох Гуравдагч улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрүүлэхийг хүсэлт гаргагч Талын Хууль зүйн яамнаас дамжин өнгөрүүлэх хүсэлт хүлээн авагч Талын Хууль зүйн яаманд гаргасан, холбогдох бүх баримт бичгийг хавсаргасан хүсэлтийг үндэслэн зөвшөөрнө.

Хэлэлцэн тохиролцогч Тал өөрийн харьяат иргэнийг дамжин өнгөрүүлэхээс татгалзаж болно.

3. Шилжүүлэх хүсэлт хүлээн авсан Тал саатуулагдсан этгээдийг суллах хүсэлт гаргаагүй бол уг этгээдийг хүсэлт гаргагч Талын нутаг дэвсгэрт болон шаардлагатай тохиолдолд дамжин өнгөрүүлэх хүсэлт хүлээн авсан Талын нутаг дэвсгэрт саатуулсан хэвээр байлгана.

### **12 дугаар зүйл**

1. Хүсэлт гаргагч Талын шүүх эрх мэдлийн байгууллагад зарлан дуудах хуудасны дагуу хүрэлцэн ирсэн гэрч, эсхүл шинжээчийг түүний иргэний харьяаллаас үл хамааран хүсэлт хүлээн авагч Талын нутаг дэвсгэрээс гарахаас өмнө болсон үйл хэрэг болон яллах ажиллагаатай холбогдуулан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд татан оролцуулахгүй, саатуулахгүй буюу аливаа хэлбэрээр түүний хувийн эрх чөлөөг хязгаарлахгүй.

2. Зарлан дуудах хуудасны дагуу түүний эсрэг үүсгэсэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлэх үндэслэл болсон үйл хэрэгтэй хариу өгөхөөр хүсэлт гаргагч Талын шүүх эрх мэдлийн байгууллагад хүрэлцэн ирсэн этгээдийг түүний иргэний харьяаллаас үл хамааран хүсэлт хүлээн авагч Талын нутаг дэвсгэрээс гарахаас өмнө болсон, зарлан дуудах хуудсанд дурдаагүй үйл хэрэг болон яллах ажиллагаатай холбогдуулан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд татан оролцуулахгүй, саатуулахгүй буюу аливаа хэлбэрээр түүний хувийн эрх чөлөөг хязгаарлахгүй.

3. Гэрч, шинжээч, эсхүл яллагдагч шүүх эрх мэдлийн байгууллагад түүнийг байлцуулах шаардлагагүй болсон өдрөөс эхлэн үргэлжилсэн 15 өдрийн хугацаанд хүсэлт гаргагч Талын нутаг дэвсгэрээс гарч явах бололцоо байсан хэдий ч тухайн нутаг дэвсгэр дээр байсан хэвээр байвал, эсхүл гарч яваад эргэн ирсэн бол энэхүү зүйлд заасан баталгаа дуусгавар болно.

## **IV бүлэг Шүүхийн материал**

### **13 дугаар зүйл**

1. Хүсэлт хүлээн авагч Тал нь Хэлэлцэн тохиролцогч аль нэг Талын шүүх эрх мэдлийн байгууллагаас хүссэний дагуу, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шаардлагатай байгаа шүүхийн материалын хэсгээс болон тэдгээрийн талаарх мэдээллийг, түүний өөрийн шүүх эрх мэдлийн байгууллагаас адил тохиолдолд олгож болох хэмжээнд шилжүүлж өгнө.

2. Энэхүү зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад тохиолдолд хүсэлтийг хүсэлт хүлээн авагч Талын хууль тогтоомж, дүрэм журам, практикт нийцүүлсэн байна.

**V бүлэг**  
**Хянан шийдвэрлэх ажиллагаа**

**14 дүгээр зүйл**

1. Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлтэд дараах зүйлийг тусгана:

- a. хүсэлт гаргасан эрх бүхий байгууллага,
- b. хүсэлт гаргах болсон зүйл ба шалтгаан,
- c. боломжтой бол холбогдох этгээдийн биеийн байцаалт болон иргэний харьяаллын тухай мэдээлэл,
- d. шаардлагатай бол хүсэлтийг хүлээн авах этгээдийн нэр болон хаяг.

2. Үүнээс гадна энэхүү конвенцын 3, 4, 5 дугаар зүйлд заасан эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай хүсэлтэд гэмт хэргийн тодорхойлолт болон үйл хэргийн товч танилцуулгыг тусгана.

**15 дугаар зүйл**

1. Энэхүү конвенцын 3, 4 болон 5 дугаар зүйлд заасан эрх зүйн туслалцаа үзүүлэх хүсэлт, түүнчлэн 11 дүгээр зүйлд заасан хүсэлтийг хүсэлт гаргагч Талын Хууль зүйн яамнаас хүсэлт хүлээн авагч Талын Хууль зүйн яаманд хүргүүлэх бөгөөд хариуг мөн адил шугамаар буцаан хүргүүлнэ.

2. Яаралтай тохиолдолд эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай хүсэлтийг хүсэлт гаргагч Талын шүүх эрх мэдлийн байгууллагаас хүсэлт хүлээн авагч Талын хуулийн байгууллагад шууд хүргүүлж болно. Хариуг энэхүү зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан шугамаар холбогдох бичиг баримтын хамт буцаан хүргүүлнэ.

3. Энэхүү конвенцын 13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хүсэлтийг холбогдох шүүх эрх мэдлийн байгууллагаас хүсэлт хүлээн авагч Талын зохих эрх бүхий байгууллагад шууд хүргүүлж болох бөгөөд хариуг тэдгээр эрх бүхий байгууллага шууд буцаан хүргүүлж болно. Энэхүү конвенцын 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүсэлтийг хүсэлт гаргагч Талын Хууль зүйн яамнаас хүсэлт хүлээн авагч Талын Хууль зүйн яаманд хүргүүлнэ.

4. Энэхүү зүйлийн 1 ба 3 дахь хэсэгт заасан эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлтээс бусад, тухайлбал ял сонсгохоос өмнө мөрдөн шалгах ажиллагаа явуулахад туслалцаа үзүүлэх хүсэлтийг шүүх эрх мэдлийн байгууллагууд хоорондоо шууд дамжуулж болно.

5. Энэхүү конвенцын дагуу шууд дамжуулахыг зөвшөөрсөн тохиолдолд Олон Улсын Эрүүгийн Цагдаагийн Байгууллага /Интерпол/-аар дамжуулж болно.

6. Хэлэлцэн тохиролцогч Тал энэхүү конвенцод гарын үсэг зурах үед, эсхүл батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулахаар хүргүүлэх үедээ Европын Зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн даргад хандан мэдэгдэл гаргах замаар туслалцаа үзүүлэх тухай зарим, эсхүл бүх хүсэлтийг энэхүү зүйлд заасан сувгаас өөр сувгаар, эсхүл энэхүү зүйлийн 2 дугаар хэсэгт заасан тохиолдлын хувьд эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай хүсэлтийн хуулбарыг Хууль зүйн яаманд давхар хүргүүлж байхыг мэдэгдэж болно.

7. Энэхүү зүйлийн заалтууд нь Хэлэлцэн тохиролцогч Талуудын холбогдох эрх бүхий байгууллага хооронд туслалцаа үзүүлэх хүсэлтийг шууд дамжуулахаар заасан Хэлэлцэн тохиролцогч Талуудын хүчин төгөлдөр үйлчилж буй хоёр талт гэрээ, эсхүл тохиролцооны заалтыг хөндөхгүй.

### **16 дугаар зүйл**

1. Энэхүү зүйлийн 2 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан тохиолдолд хүсэлт болон хавсаргасан баримт бичгийн орчуулга хийх шаардлагагүй.

2. Хэлэлцэн тохиролцогч Тал бүр гарын үсэг зурах үед, эсхүл батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулахаар хүргүүлэх үедээ Европын Зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн даргад хандан мэдэгдэл гаргах замаар хүсэлт болон хавсаргасан баримт бичгүүдийг өөрийнх нь эх хэл, эсхүл түүний заасан Европын Зөвлөлийн албан ёсны хэлний аль нэг рүү орчуулсан орчуулгын хамт ирүүлэх шаардлага тавих эрхээ хадгалж болно. Хэлэлцэн тохиролцогч бусад Талууд харилцан адил байх зарчим хэрэглэж болно.

3. Энэхүү зүйл нь Хэлэлцэн тохиролцогч хоёр буюу түүнээс дээш Талуудын хооронд хүчин төгөлдөр үйлчилж буй, эсхүл байгуулагдах гэрээ буюу тохиролцоонд тусгагдсан хүсэлт болон хавсаргасан баримт бичгүүдийн орчуулгын талаарх заалтыг хөндөхгүй.



### **17 дугаар зүйл**

Энэхүү конвенцын дагуу хүргүүлж буй гэрчийн мэдүүлэг, эсхүл баримт бичигт аливаа хэлбэрийн баталгаажуулалт шаардлагагүй.

### **18 дугаар зүйл**

Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлт хүлээн авагч байгууллага нь уг хүсэлтийг гүйцэтгэх эрх мэдэлгүй бол өөрийн улсын эрх бүхий байгууллагад *ex officio* шууд дамжуулах бөгөөд энэ тухайгаа хүсэлт гаргагч Талд, уг хүсэлтийг шууд сувгаар ирүүлсэн бол шууд сувгаар мэдээлнэ.

### **19 дүгээр зүйл**

Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэхээс татгалзсан аливаа тохиолдлын шалтгааныг мэдэгдэнэ.

### **20 дугаар зүйл**

Энэхүү конвенцын 10 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтыг дагаж мөрдөхийн хамт эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлтийг гүйцэтгэхэд хүсэлт хүлээн авагч Талын нутаг дэвсгэрт шинжээчийг байлцуулахтай холбоотой зардал, эсхүл энэ конвенцын 11 дүгээр зүйлд заасан үндэслэлээр саатуулагдсан этгээдийг шилжүүлэхэд гарсан зардлаас бусад зардлыг нөхөн төлөх шаардлагагүй.

## **VI бүлэг**

### **Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдуулан мэдээлэл өгөх**

### **21 дүгээр зүйл**

1. Хэлэлцэн тохиролцогч Талууд энэхүү конвенцын 15 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасан бүрэн эрхээ эдэлснээс бусад тохиолдолд хэлэлцэн тохиролцогч нэг Талаас хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын шүүхэд хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдуулан хүргүүлэх мэдээллийг холбогдох Хууль зүйн яамд хоорондоо дамжуулна.

2. Хүсэлт хүлээн авагч Тал энэхүү мэдээллийн дагуу авсан аливаа арга хэмжээний талаар хүсэлт гаргагч Талд мэдээлэх бөгөөд шүүгчийн уншиж сонгосон аливаа шийдвэр, бичлэгийн хуулбарыг хүргүүлнэ.

3. Энэхүү зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу хүргүүлэх мэдээллийн хувьд 16 дугаар зүйлийн заалтыг хэрэглэнэ.





## **VII бүлэг** **Шүүхийн материалаас мэдээлэл солилцох**

### **22 дугаар зүйл**

Хэлэлцэн тохиролцогч аливаа Тал хэлэлцэн тохиролцогч нөгөө Талд уг Талын иргэдтэй холбоотой шүүхийн материалд авагдсан бүх шийтгэх тогтоол болон авсан арга хэмжээний талаар мэдээлнэ. Хууль зүйн яамд ийм мэдээллийг нэг нэгэндээ хамгийн багадаа жилд нэг удаа дамжуулна. Хэрэв холбогдох этгээд хэлэлцэн тохиролцогч хоёр болон түүнээс дээш Талын иргэний харьяалалтай бол нутаг дэвсгэрт нь ял шийтгүүлсэн Талын иргэн биш тохиолдолд уг мэдээллийг хэлэлцэн тохиролцогч Тал тус бүрд өгнө.

## **VIII бүлэг** **Төгсгөлийн заалт**

### **23 дугаар зүйл**

1. Хэлэлцэн тохиролцогч аливаа Тал энэхүү конвенцод гарын үсэг зурах, эсхүл батламж жуух бичиг буюу нэгдсэн орсон тухай баримт бичгээ хадгалуулахаар хүргүүлэх үедээ энэхүү конвенцын аливаа заалт, эсхүл заалтуудтай холбогдуулан тайлбар гаргаж болно.

2. Тайлбар гаргасан хэлэлцэн тохиролцогч аливаа Тал нөхцөл байдал бүрдсэн даруйд тайлбараа буцаан авна. Тайлбарыг Европын Зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэх замаар буцааж авна.

3. Энэхүү конвенцын аль нэг заалттай холбогдуулан тайлбар гаргасан хэлэлцэн тохиролцогч Тал хэлэлцэн тохиролцогч нөгөө Талаас тухайн заалтыг зөвхөн өөрийн зөвшөөрсөн хэмжээнд хэрэглэхийг шаардаж болно.

### **24 дүгээр зүйл**

Хэлэлцэн тохиролцогч аливаа Тал нь энэхүү конвенцод гарын үсэг зурах, эсхүл батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулахаар хүргүүлэх үедээ Европын Зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэл гаргах замаар энэхүү конвенцын зорилгоор аль байгууллагыг шүүх эрх мэдлийн байгууллага хэмээн үзэхийг тодорхойлж болно.



### **25 дугаар зүйл**

1. Энэхүү конвенц нь хэлэлцэн тохиролцогч Талуудын нутаг дэвсгэрт үйлчилнэ.

2. Бүгд Найрамдах Франц Улсын хувьд Алжирт болон далайн чанадад байгаа газруудад хамаарна, Итали Улсын хувьд Италийн засаг захиргааны харьяа Сомалийн нутаг дэвсгэрт үйлчилнэ.

3. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс нь Европын Зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэл хүргүүлэх замаар энэхүү конвенцын үйлчлэх хүрээг Берлин мужийн нутаг дэвсгэрт үйлчлэхээр тэлсэн.

4. Нидерландын Хаант Улсын хувьд энэхүү конвенцын үйлчлэх хүрээнд түүний Европ дахь хэсгийн нутаг дэвсгэр хамаарна. Нидерландын Хаант Улс нь энэхүү конвенцын үйлчлэлийг Европын Зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэх замаар Нидерландын Антилийн арлууд, Суринам болон Нидерландын Шинэ Гвинейн газар нутагт хамааруулж болно.

5. Хэлэлцэн тохиролцогч хоёр болон түүнээс дээш Талууд хоорондын шууд тохиролцоогоор, тус тохиролцоонд заасан нөхцөлийн дагуу энэхүү Конвенцын үйлчлэлийг эдгээр Талуудын аль ч нутаг дэвсгэрт, энэхүү зүйлийн 1, 2, 3 болон 4 дэх заалтад заасан нутаг дэвсгэрээс бусад нутаг дэвсгэрт гадаад харилцааных нь өмнөөс хариуцлага хүлээдэг бол хамааруулж болно.

### **26 дугаар зүйл**

1. Энэхүү конвенцын 15 дугаар зүйлийн 7 болон 16 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг дагаж мөрдөхийн хамт энэхүү конвенц нь түүнийг хэрэгжүүлдэг улсуудын хувьд хэлэлцэн тохиролцогч Талуудын хооронд байгуулсан эрүүгийн хэргийн асуудлаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай аливаа гэрээ, конвенц буюу хоёр талт гэрээний заалтаас давуу эрхтэй байна.

2. Энэхүү конвенц нь тухайн салбарын эрх зүйн харилцан туслалцааны тодорхой асуудлыг зохицуулдаг аливаа бусад хоёр болон олон талт олон улсын гэрээний дагуу хүлээсэн үүргийг хөндөхгүй.

3. Хэлэлцэн тохиролцогч Талууд энэхүү конвенцын заалтуудад зөвхөн нэмэлт байдлаар, эсхүл түүнд тусгасан зарчмуудын хэрэглээг дэмжих зорилгоор эрүүгийн хэрэгт эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай хоёр болон олон талт гэрээг өөр хоорондоо байгуулж болно.

4. Хоёр болон түүнээс дээш хэлэлцэн тохиролцогч Талууд хоорондын эрүүгийн хэргийн асуудлаар эрх зүйн харилцан туслалцааг эдгээр талуудад холбогдох нутаг дэвсгэрт нь эрх зүйн харилцан туслалцааны арга хэмжээг харилцан хэрэгжүүлж болохыг тусгасан загвар хууль тогтоомж, эсхүл тогтолцооны үндсэн дээр хэрэгжүүлдэг бол энэхүү конвенцын заалтаас үл хамааран энэ салбар дахь өөрсдийн харилцаагаа тэрхүү хууль тогтоомж, эсхүл тогтолцооны дагуу зохицуулж болно. Хэлэлцэн тохиролцогч Талууд энэхүү заалтын дагуу энэхүү конвенцыг харилцан хэрэглэх боломжгүй, эсхүл ирээдүйд хэрэглэх боломжгүй болох тохиолдолд энэ тухайгаа Европын Зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэнэ.

### **27 дугаар зүйл**

1. Энэхүү конвенц нь Европын Зөвлөлийн гишүүд гарын үсэг зурахад нээлттэй. Энэхүү конвенцыг соёрхон батална. Европын Зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн даргад батламж жуух бичгийг хадгалуулна.

2. Энэхүү конвенц нь гурав дахь батламж жуух бичгийг хадгалуулсан өдрөөс эхлэн 90 хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

3. Энэхүү конвенцод гарын үсэг зурж, дараа нь соёрхон баталсан аль ч улсын хувьд энэхүү конвенц нь батламж жуух бичгээ хадгалуулсан өдрөөс эхлэн 90 хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

### **28 дугаар зүйл**

1. Европын Зөвлөлийн сайд нарын хороо нь Европын Зөвлөлийн гишүүн бус аль ч улсыг энэхүү конвенцод нэгдэн орохыг урьж болно. Ийм урилга илгээх эсэхийг энэхүү конвенцыг соёрхон баталсан Европын Зөвлөлийн гишүүд санал нэгтгэйгээр шийдвэрлэнэ.

2. Европын Зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн даргад нэгдэн орох тухай баримт бичгийг хадгалуулснаар уг конвенцод нэгдэн орох бөгөөд энэ нь хадгалуулснаас эхлэн 90 хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

### **29 дүгээр зүйл**

Хэлэлцэн тохиролцогч аливаа Тал Европын Зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэл хүргүүлэх замаар энэхүү конвенцыг өөрийн хувьд цуцалж болно. Европын Зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн дарга энэхүү мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш 6 сарын дараа уг конвенц тухайн улсын хувьд хүчингүй болно.



### **30 дугаар зүйл**

Европын Зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн дарга Европын Зөвлөлийн гишүүдэд болон энэхүү конвенцод нэгдэн орсон улсуудын Засгийн газарт дараах зүйлийг мэдэгдэнэ:

- a. гарын үсэг зурсан улсын нэр болон соёрхон баталсан, эсхүл нэгдэн орсон тухай батламж жуух бичгийг хадгалуулсан тухай;
- b. энэхүү конвенц хүчин төгөлдөр болох огноо;
- c. энэхүү конвенцын 5 дугаар зүйлийн 1 дэх заалт, 7 дугаар зүйлийн 3 дахь заалт, 15 дугаар зүйлийн 6 дахь заалт, 16 дугаар зүйлийн 2 дахь заалт, 24 дүгээр зүйл, 25 дугаар зүйлийн 3 ба 4 дэх заалт, 26 дугаар зүйлийн 4 дэх заалтын дагуу хүлээн авсан аливаа мэдэгдлийн тухай;
- d. энэхүү конвенцын 23 дугаар зүйлийн 1 дэх заалтын дагуу гаргасан тайлбар;
- e. энэхүү конвенцын 23 дугаар зүйлийн 2 дахь заалтын дагуу гаргасан тайлбарыг буцаан авсан тухай;
- f. энэхүү конвенцын 29 дүгээр зүйлд заасны дагуу цуцалсан тухай мэдэгдэл хүлээн авсан болон цуцалсан огнооны тухай.

ХЭМЭЭСНИЙГ НОТОЛЖ, зохих ёсоор бүрэн эрх нь олгогдсон доор дурдсан төлөөлөгчид энэхүү конвенцод гарын үсэг зурав.

Страсбург хотноо 1959 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр англи, франц хэлээр адил хүчинтэй нэг эх хувь үйлдэв. Эх бичвэрийг Европын Зөвлөлийн архивд хадгална. Европын Зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн дарга энэхүү конвенцын баталгаажуулсан хуулбарыг түүнд гарын үсэг зурсан болон нэгдэн орсон Засгийн газар бүрд хүргүүлнэ.



**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: [turiin\\_medeel@parliament.mn](mailto:turiin_medeel@parliament.mn)

**Утас:** 262420

Хэвлэлийн хуудас: 5.75

**Индекс: 200003**